



I-IV/2021

Тархаасан: 2021 оны 5 дугаар сарын 12



Хаврын тариалалтад 45.2 мянган тонн буудайн үр бэлэн байгаа нь өмнөх оноос 4.3 мянган тонн буюу 10.6 хувиар нэмэгдлээ

Хаврын тариалалтад бэлэн байгаа буудайн үр 2021 оны 5-р сарын 1-ний байдлаар 45.2 мянган тонн байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.3 (10.6%) мянган тонноор өссөн байна.

Хүснэгт 1. Хаврын тариалалтад бэлэн байгаа буудайн үрийн хэмжээ, жил бүрийн 5-р сарын 1-ний байдлаар, мянган тонн

	2018.V	2019.V	2020.V	2021.V	$\frac{2021.V}{2020.V}$
	мянган тонн				хувь
Нийт үрийн хэмжээ	63.2	43.4	40.9	45.2	110.6
Иргэд, ААНБ	30.6	32.0	33.4	33.7	100.9
Бусад	32.6	11.4	7.5	11.6	153.4

Харин энэ оны 5-р сарын 1-ний байдлаар, өргөн холбооны 94.6%, бүх төрлийн сийрүүлэгчийн 93.1%, дугуйт тракторын 92.5%, гинжит тракторын 71.9% нь хөрс боловсруулалт, тариалалтад ажиллахад бэлэн болсон байна.

Хүснэгт 2. Хөрс боловсруулалт, тариалалтад ажиллах зарим техникийн бэлэн байдал, 5-р сарын 1-ний байдлаар, хувиар

	2018.V	2019.V	2020.V	2021.V
	хувь			
Өргөн холбоо	96.0	93.9	96.4	94.6
Бүх төрлийн сийрүүлэгч	94.6	86.7	95.6	93.1
Дугуйт трактор	87.0	90.1	94.3	92.5
Гинжит трактор	69.7	80.4	79.7	71.9
Анжис	92.7	93.6	96.9	94.4
Бул	89.0	91.7	92.3	97.1
Төмс, хүнсний ногооны үрлүүр	92.6	85.4	96.1	95.2

Ойлголт, тодорхойлолт:

Үр гэж тухайн сортын нөхөн үржлийг хангах чадвартай, дахин сэргээх, үржүүлэх болон аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа амьд үр, суулгац, тарьцыг ойлгоно.

Техникийн бэлэн байдлыг тодорхойлохдоо хөрс, боловсруулалт, тариалалтад ажиллахад бэлэн техникийн тоог бүртгэлтэй техникийн тоо хэмжээнд нь харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

Эх үүсвэр: Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 6 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын

дарга Э.Эрдэнэсан

Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын

статистикч Х.Энхжавхлан

Утас : (976-51)-261565

